

Product Data Sheet

Version no: 08/09 (reprinted 01/12)

Sikaflex® 11FC

Sikaflex® 11 FC

1 Бүрэлдэхүүнт Полиуретан заагны чигжээс цавуу

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sikaflex 11FC нь 1 бүрэлдэхүүнт полиуретан суурьтай барилгын заагны уян хатан чигжээс ба өндөр бат бэхтэй цавуу юм. Sikaflex 11FC нь урсдаггүй материал бөгөөд агаарын чийгшилтэй урвалд орж, уян хатан полимер бүхий бат бөх бэхжилт үүснэ.

Хэрэглээ:

Sikaflex 11FC нь барилгын угсралт болон иргэний инженерчлэлийн үйлдвэрлэлд урт хугацаанд хэрэглэгдэх заагны уян хатан чигжээс болон цавууны зориулалтаар хэрэглэгдэнэ.

Sikaflex 11FC –ийг заагны чигжээс зорилгоор:

- Бетон шалны зүсэлт болон барилгын заагийг дүүргэх зорилгоор
- Шаазан болон шавар плитаны хоорондын чигжих
- Боржин, гантиг г.м байгалийн чулуу хооронд чигжих
- Усны болон агааржуулалтын хоолойн эргэн тойрныг чигжих
- Бетон шал болон машин тоног төхөөрөмжийн хоорондох уян холбоос
- Ус нөөцлөх савны зааганд хийгдэх усанд тэсвэртэй чигжээс

Sikaflex 11FC –ийг бат бөх цавуу шаардагдах дараах эдлэлд хэрэглэнэ:

- Бүтээцэд плита, тоосго, зүсмэл модон хавтан, ялтасан төмрийг даралтаар бүрэх г.м хөнгөн чанартай барилгын эд ангийг нааж тогтооход хэрэглэнэ.
- Хөнгөн цагааныг бетонтой, модон хавтанг төмөртэй г.м дулааны ялгаатай коэффициенттай барилгын эд ангийг хооронд нь наахад ашиглана.
- Бетон, плитан шал, хананд ариун цэврийн тоноглолыг бат бөх тогтоох зорилгоор хэрэглэнэ.
- Агааржуулалтын хоолой, гэрлэн дохионы хөндий зааг г.м метал эдлэлүүдийг өндөр бат бэхээр нааж холбоход ашиглана
- Силос хоолой, танк, төмөр шон г.м үйлдвэрийн аргаар бэлтгэсэн төмөр бүтээцийн хөндий залгаасанд хэрэглэгдэнэ.

Sikaflex 11FC –ийг жийргэвийг битүүлэх зорилгоор:

- Бэлэн хийц эдлэлийн эд ангийн залгаас, дамжуулах хоолойг уснаас хамгаалах зорилгоор
- Ган төмөр хоолойн холбоос, углуурга, хошууны залгааст жийргэвчид хэрэглэнэ



- Агааржуулалтын хоолойн хошууны залгаас хооронд жийргэвчид
- Тэгш бус гадаргууг хооронд ньбитүүмжлэх шаардлагатай эд ангид

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Хэрэглээ хялбар, талбай дээр холих шаардлагагүй бөгөөд үүнээс үүдэн буруу хольц, хаягдал бүтээгдэхүүний гарц буурна
- Босоо болон таазны гүйцэтгэлд урсахгүй
- Цаг уур болон элэгдэлд тэсвэртэй
- Хүнсний үйлдвэрлэл болон ундны устай хүрэлцэх орчинд хэрэглэх боломжтой
- Дээрээс нь давхарлан будах боломжтой (урьдчилан туршиж үзэх шаардлагатай)
- Хатуулагын чанар өндөртэй
- Олон төрлийн барилгын материалтай наалдах чадвар сайтай, суурь түрхлэг шаардлагагүй
- Бэхжилт хурдан
- Химийн бодисын тэсвэр сайтай
- Боржин болон гантиг зэрэг байгалийн чулуунд хэрэглэхэд толбо үүсэхгүй
- Тасралтын бат бэх өндөртэй
- Зэвэрдэггүй, үнэргүй

Бүтээгдэхүүний мэдээллийн хуудас

Хэлбэр / Төрөл	Уян хатан полиуретан
Сав баглаа боодол	310 мл (хайрцаганд 12 ш): цагаан, саарал, хар өнгөний сонголттой 600 мл (хайрцаганд -20 ш): саарал өнгөтэй
Хадгалах нөхцөл / хугацаа	Сав баглаа боодол онгойж, цоороогүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 12 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд +10°C+25°C орчинд хадгална.

Техникийн үзүүлэлт

Нягт	~ 1.2 кг/л
Ашиглалтын температур	-40°C + 80°C (усан дотор хамгийн ихдээ +50°C)
Гүйцэтгэлийн температур	+5°C + 40°C
Хатуулагын чанар	40-45 (DIN 53 505)
Уян хатан байдал	> 90%
Суналтын бат бэх	+20°C орчинд 0,5 МПа – 50%
Урагдалтын тэсвэр	1,5 МПа
Суналтын тасралт	> 400% (DIN 53 455)

Хөдөлгөөний чадвар	залгаасын өргөний $\pm 10\%$. Нийт хөдөлгөөний чадвар = 20%
Бүрхүүл үүсэх хугацаа	1-2 цаг (орчны температураас шалтгаална)
Бэхжилтийн зэрэг	~ 3 мм / 24 цагт (+20°C, 60%-ийн харьцангуй чийгшилтэй орчинд)
Хортой байдал	Ямар нэгэн хязгаарлалт байхгүй

Ерөнхий хэрэглээн дэх залгаасын орон зайн холбоо	12 мм хүртэлх өргөнтэй залгаас: өргөн : гүний харьцаа = 1 : 1
	12 мм – 24 мм өргөнтэй залгаас: залгаасын харьцаа = өргөн x 12 мм гүн
	24 мм-ээс дээш өргөнтэй залгаас: өргөн : гүний харьцаа = 2 : 1

Гүйцэтгэлийн нөхцөлүүд

Гадаргуун чанар

- Заагны гадаргуу тоос шороо, тос тосоол зэрэг урвалд орж болзошгүй чигжээс цавууны барьцалтад сөргөөр нөлөөлөх элдэв бохирдолгүй цэвэрхэн, бат бэх нэгэн жигд гадаргуу байх шаардлагатай. Ямар нэгэн сул эд, хэсэг байх ёсгүй.

Дэр хөөсөнцөр / Барьцалтын хаалт

- Нээлттэй суурьтай залгааст чигжээс бүтээгдэхүүнийг тохиромжит гүнтэй хийж өгөхийн тулд дэр Sika PEF backing Rod –ийг хэрэглэх буюу тохиромжит хэмжээтэй дэр хөөсөнцөрийг хийж өгөх шаардлагатай.
- Хэрэв залгаас нь хатуу биет суурьтай байвал чигжээс бүтээгдэхүүнийг ар хананд наалдуулахгүйн тулд хаалтын тууз хэрэглэх шаардлагатай. Ингэснээр чигжээс бүтээгдэхүүн залгаасын гүн дагуу ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хөдлөх боломжоор хангагдана.

Суурь түрхлэг

- Sikaflex 11FC нь олон төрлийн гадаргуутай наалдах чадвар сайтай бүтээгдэхүүн юм. Гэвч олон давхар барилга, усан доорх залгаас, өндөр ачаалал бүхий залгаас, цаг уурын хүнд нөхцөлд ил байх залгаас г.м аюултай орчинд болон өндөр үзүүлэлттэй гүйцэтгэлд гадаргуун суурь түрхлэг болон цэвэрлэгчийг хэрэглэхийг зөвлөж байна.
- Хэрэв суурь түрхлэг хэрэглэхгүй тохиолдолд урьдчилсан туршилт хийж, тухайн гадаргуу дээр зөвлөсөн цэвэрлэгээний аргачлалын дагуу цэвэрлэж гүйцэтгэл хийхэд, ашиглалтын нөхцөлд тохирсон, шаардлагатай бат бэхээр наалдсан эсэхийг тодорхойлох хэрэгтэй (манай Техникийн Хэлтэстэй холбогдож зөвлөгөө авах боломжтой).
- Бетон, чулуун өрлөг, тоосго, модон зэрэг нүхжилттэй гадаргууд Sika Primer 3N суурь түрхлэгийг хэрэглэнэ.
- Хөнгөн цагаан шаазан, бэхэжсэн эпоксид болон полиэстер зэрэг нүхжилтгүй гадаргууд Sika Activator 205 суурь түрхлэгийг хэрэглэнэ.
- Суурь түрхлэг түрхсэн тохиолдолд түүнийг бүрэн хатсаны дараа Sikaflex 11FC-г хэрэглэнэ.
- Суурь түрхлэгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Sika Primer бүтээгдэхүүний техникийн зааварчилгааны хуудаснаас үзэх болон манай Техникийн Хэлтэстэй холбогдох авах боломжтой.

Хэрэглээ

- Туузан наалтаар залгаасын гадна 2 талд нааж өгнө.
- Sikaflex 11FC –ийг чигжээсний гар буу болон хийн даралтад буу ашиглан, болзошгүй агаарын нүхийг арилгах зорилгоор өнцөг үүсгэн түрхэж өгнө. Чигжээс бүтээгдэхүүнийг залгаасанд нэгэн жигд, залгаасын 2 талд хананд сайтар барьцалдуулан

наалдуулан шахаж өгөх хэрэгтэй. Өнгөн хэсгийг тэгш, гөлгөр болгохын тулд багажаар дарж өгөх боломжтой. Мөн багажаар дарж өгсөнөөр залгаасын 2 талын хананд барьцалдуулан наалдах чадварыг нэмэгдүүлнэ.

- Чигжээс бүтээгдэхүүн бэхжихээс өмнө туузан наалтыг ав.
- Хэрэв Sikaflex 11FC-ийг хошууны хоорондын нягт жийргэвч хэлбэрээр ашиглах тохиолдолд чигжээс бүтээгдэхүүнийг бэхжихээс өмнө хошууны боолтуудыг чангалж боож болохгүй.
- Хэрэв Sikaflex 11FC-ийг барилгын болон инженерчлэлийн эд ангийг хооронд нь наах зорилгоор ашиглаж байгаа бол шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүнийг бүрэн бэхэжтэл түр тулаас хийж өгөх хэрэгтэй.

Багажыг цэвэрлэх

- Чигжээс цавууг хэрэглэсэний дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ Sika Thinner Cг цэвэрлэгч бодисуудаар цэвэрлэнэ. Хатсан болон бэхэжсэн бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар нь цэвэрлэх боломжтой.

Анхаарах зүйлс / Боломжууд

- Sikaflex 11FC нь Полиэтилен, Полипропилен, Полибутилен, Поликарбонат, силикон болон Тефлон дээр наалдахгүй. Гадаргуун талаар эргэлзээтэй асуудал байвал манай Техникийн хэлтэстэй холбогдож зөвлөгөө авах буюу барьцалдан наалдах эсэхийг урьдчилан туршиж үзэх хэрэгтэй.
- Sikaflex 11FC-ийг цавуу болон жийргэвчийг битүүлэх зорилгоор ашиглах тохиолдолд гүйцэтгэлийн зузааныг хамгийн багадаа 2 мм түрхэж өгөх шаардлагатай.
- Гүйцэтгэлийн дараа бүтээгдэхүүнийг 2-3 цаг уснаас хамгаалах хэрэгтэй
- Цагаан өнгийн полиуретан чигжээс нь ашиглалтын тодорхой хугацааны дараа өнгөө бага зэрэг алдах магадлалтай.
- Sikaflex 11FC дээр ямар нэгэн түрхлэг түрхэх нь бүтээгдэхүүний хөдөлгөөнт чанарт сөргөөр нөлөөлөх боломжтой учир давхарлан будахгүй байхыг зөвлөж байна.
- Sikaflex 11FC-ийг бэлтгэгдсэн талбайд хэрэглэхээс өмнө наалдан барьцалдах тестийг урьдчилан хийж шалгах шаардлагатай.
- Гидростатик даралт бүхий залгаасанд чигжээс бүтээгдэхүүнийг хэрэглэхдээ бат бэх гадаргууд барьцалдуулан нааж өгөх шаардлагатай.
- Бүх төрлийн уян хатан полимер бүхий чигжээс бүтээгдэхүүний нэгэн адил, Sikaflex 11FC-ийг хлоржуулсан ус бүхий усан бассейнд удаан хугацаагаар ил байлгахад бүтээгдэхүүний чанар муудах болно. Усан бассейны зааг залгаасд **Sikadur Combiflex SG** системийг (Бүтээгдэхүүний техникийн зааварчилгааны хуудастай танилцана уу) хэрэглэхэд тохиромжтой.
- Sikaflex 11FC-ийг бүрэн бэхжүүлж хатаасны дараа дээрээс нь ундны ус хийх боломжтой.
- Sikaflex 11FC-ийг бүтээцийн шилэн эдлэл буюу гадна фасаданд хэрэглэж болохгүй.
- Sikaflex Elastomeric Sealants – Sikaflex Уян Полимер бүхий Чигжээс – техникийн зааварчилгааны хуудаснаас зааг залгаасны бүтэц болон залгаасын хөдөлгөөний тооцоололтой танилцана уу.

Дүгнэлт

- Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт

- Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэдээлэл

- Ховор тохиолдох арьсны цочролоос урьдчилан сэргийлж хувийн хамгаалах хэрэгсэл болон бээлийн өмсөхийг зөвлөж байна. Ажлын засварлагаан болон ажил дууссаны дараа бохир хувцасаа сольж гараа гараа сайтар угаах хэрэгтэй.
- Тухайн орон нутгийн болон бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр заасан тусгагдсан Эрүүл, Аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжүүдийг хангаж ажиллах хэрэгтэй.
- Дэлгэрэнгүй мэдэллэгийг Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн зааварчилгааны хуудаснаас авах боломжтой.

Чухал санамжууд

- Бүтээгдэхүүний хаягдлыг ус болон хөрсөнд хаяж болохгүй, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хаягдал устгах цэг талбайд устгана.
- Аюулгүй ажиллагаа, физик шинж чанарууд болон байгаль орчинтой холбоотой бусад мэдээллүүд Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Тээвэрлэлтийн ангилал

- Sikaflex 11FC тээвэрлэлтийн аюулгүй зэрэглэлтэй бүтээгдэхүүн болно.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika (NZ) Ltd
PO Box 19192
Avondale
Auckland
New Zealand

Phone: 0800 SIKA NZ 0800 745 269
Fax: 0800 SIKA FAX 0800 745 232
Email: info@nz.sika.com www.sika.co.nz

Sika®